НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР

2026 IX

НИЙСЛЭЛИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

www.1212.mn

НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР

АГУУЛГА

	Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд, 2024-2026 он	4
	Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд, дүүргээр	4
I	Эрүүл мэнд	6
II	Гэмт хэрэг	10
III	Төсөв	13
IV	Хэрэглээний үнэ	17
V	Мал аж, ахуй	22
VI	Аж үйлдвэр	25
VII	Хотын нийтийн аж ахуй	30
VIII	Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол	32

ХҮСНЭГТ 1. НИЙСЛЭЛИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX
Шинээр төрсөн хүүхэд		Хүн	23 539 ↓9.4	22 226 ↓5.6	22 083 ↓0.6
Халдварт өвчнөөр өвчлөгчид		Хүн	14 629 ↓12.4	30 372 ↑2.1**	20 961 ↓31.0
Бүртгэгдсэн гэмт хэрэг		Тоо	22 941 ↑48.0	26 679 ↑16.3	28 594 ↑7.2
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)		Хувь	0.1 ↓0.2	0.1 =	0.4 ↑0.3
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	Төгрөг	3 381 ↓2.5	3 594 ↑6.3	3 595 ↑0.02
	Юань (БНХАУ)	Төгрөг	478 ↓0.6	504 ↑5.4	536 ↑6.3
	Рубль (ОХУ)	Төгрөг	37 ↑2.8	44 ↑18.9	42 ↓4.5
Нийслэлийн төсвийн орлого		Тэрбум төгрөг	2 020.1 ↑40.2	2 669.8 ↑32.2	2 940.5 ↑10.1
Нийслэлийн төсвийн зарлага		Тэрбум төгрөг	2 931.2 ↑86.6	3 803.7 ↑29.8	3 281.4 ↓13.7
Агаарын дундаж температур		^{0}C	10.6	10.7	11.3

** дахин их
↓ эерэг өөрчлөлт
↑ сөрөг өөрчлөлт
= өөрчлөлтгүй

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 I-IX					2026 I-IX				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг км^2 талбайд ногдох хүн/	Тоо	357	БГД	8 797	НД	59	356	БГД	8 637	НД	59
			ЧД	1 490	БНД	47		ЧД	1 446	БНД	47
			СБД	688	БХД	32		СБД	677	БХД	30
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1 000 хүүхдэд/	0\00*	15	БХД	21	СБД	12	13	БНД	20	ХУД	8
			БНД	18	ЧД	12		НД	17	БГД	6
			СБД	12	ХУД	8		ЧД	14	БХД	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгчид	0\000	183	БЗД	204	СХД	129	125	БНД	208	ХУД	76
			БНД	170	НД	65		БЗД	124	НД	72
			ХУД	155	БХД	56		СБД	102	БХД	14
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	хувь	70	БЗД	108	НД	81	90	ХУД	401	НД	78
			ХУД	103	БХД	74		СБД	367	БНД	73
			СБД	103	БНД	22		БГД	303	БХД	23
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох гэмт хэрэг	тоо	241	СБД	395	БНД	142	258	СБД	431	НД	164
			ЧД	344	НД	83		ЧД	329	БНД	152
			ХУД	259	БХД	80		БГД	317	БХД	76

Товчилсон нэр	Дүүрэг
БНД	Багануур
БХД	Багахангай
БГД	Баянгол
БЗД	Баянзүрх
НД	Налайх
СХД	Сонгинохайрхан
СБД	Сүхбаатар
ХУД	Хан-Уул
ЧД	Чингэлтэй

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

...	мэдээлэл байхгүй
0.0	маш бага тоо
-	гүйцэтгэл байхгүй
*	урьдчилсан гүйцэтгэл
**	дахин их
1/x**	дахин бага
#	тухайн сар
1	оны эцэст
|	харьцуулагдахгүй
=	өөрчлөлтгүй

III. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	$=10^6$
тэрбум	$=10^9$
их наяд	$=10^{12}$
мян.	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
$м^2$	метр квадрат
$дм^2$	дециметр квадрат
$км^2$	километр квадрат
$м^3$	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
вт	ватт
квт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
гкал	гигакалори($=10^9$ калори)
с	секунд
мин	минут
мкг/м3	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас

Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та өөрийн гар утасны камераар доорх QR уншуулж танилцуулга үзэх боломжтой.
/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

ЭРҮҮЛ МЭНД

2026 оны эхний 9 сард 21843 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 177 (0.8%) төрөлтөөр буурчээ.

Нийслэлийн хэмжээнд 2026 оны эхний 9 сард 21843 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 177(0.8%) төрөлтөөр буурсан байна. Нийт төрөлтийн 11366 (52.0%) нь НЭМГ-ын харьяа эмнэлэгт, 10477 (48.0%) нь нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ЭМЯ-ны харьяа улс болон хувийн хэвшлийн эмнэлэгт амаржсан байна. Нийт амаржсан эхчүүдийн 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байна.

ХҮСНЭГТ 3. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний 9 сард

Үзүүлэлт	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	2026 I-IX / 2025 I-IX	
				зөрүү	хувь
Амаржсан эхийн тоо	23 321	22 020	21 843	-177	-0.8
Гэрийн төрөлт	66	59	60	1	1.7
Хяналтгүй төрөлт	162	172	146	-26	-15.1
Амьд төрсөн хүүхэд	23 539	22 226	22 083	-143	-0.6
Эхийн эндэгдэл	5	8	4	-4	-50.0
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	280	332	288	-44	-13.3
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	11.9	14.9	13.0	-1.9	-12.8

2026 оны эхний 9 сард 22083 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 143 (0.6%) хүүхдээр буурсан байна. Төрсөн нийт хүүхдийн 4176 (18.9%) нь бусад аймгийн харьяат эхчүүдээс мэндэлжээ.

ЗУРАГ 1. АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, дүүргээр



Төрсөн нийт хүүхдийн 11594 (50.6%) нь хүү, 10906(49.4%) нь охин байна. Амьд төрсөн нийт хүүхдээс 2 ихэр хүүхэд 324, 3 ихэр хүүхэд 6 байна.

Амьгүй төрөлтийн 85 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 33 тохиолдлоор буурсан байна. Амьгүй төрөлт Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Налайх, Багануур дүүрэгт хотын дунджаас өндөр байна.

ЗУРАГ 2. ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИН (1000 амьд төрөлтөд ногдох)



Нийслэлд 2026 оны эхний 9 сард бүртгэгдсэн нялхсын эндэгдлээс Баянзүрх дүүрэгт 55(19.1%) нь, Сонгинохайрхан дүүрэгт 39(13.5%) нь, Хан-Уул дүүрэгт 29(10.1%) нь, Сүхбаатар дүүрэгт 15(5.2%) нь, Баянгол дүүрэгт 13(4.5%) нь, Чингэлтэй дүүрэгт 18(6.3%) нь, Налайх дүүрэгт 9(3.1%), Багануур дүүрэгт 6(2.1%) нь бусад аймгийн харьяат 104(36.1%), Багахангай дүүрэгт бүртгэгдээгүй байна.

Нийслэлд 2026 оны эхний 9 сард 20961 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 9411 (31.0%) хүнээр буурсан байна.

ЗУРАГ 3. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварт өвчний төрлөөр нь авч үзвэл амьсгалын замын цочмог халдварт өвчин 11076 (52.8%), бэлгийн замаар дамжих халдварт өвчин 3708 (17.7%), гэдэсний халдварт өвчин 1602(7.6%), зоонозын халдварт өвчин 100 (0.5%) бусад халдварт өвчин 4475 (21.4%) байна.

ХҮСНЭГТ 4. НИЙСЛЭЛД БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний 9 сард

Төрөл	Хэмжих нэгж	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	2026 I-IX / 2025 I-IX	
					зөрүү	хувь
НИЙТ	тоо	14 629	30 372	20 961	-9 411	-31.0
	10 000 хүнд	90.4	183.0	125.1	-57.9	
Үүнээс:						
Вируст хепатит	тоо	104	122	86	-36	-29.5
	10 000 хүнд	0.6	0.74	0.51	-0.23	
Цусан суулга	тоо	1 744	911	806	-105	-11.5
	10 000 хүнд	10.8	5.49	4.81	-0.68	
Салхин цэцэг	тоо	4 127	4 792	3 236	- 1 556	-32.5
	10 000 хүнд	25.5	28.88	19.3	-9.58	
Гахай хавдар	тоо	209	66	51	-15	-22.7
	10 000 хүнд	1.3	0.40	0.3	-0.1	
Сальмонеллёз	тоо	363	367	472	105	28.6
	10 000 хүнд	2.2	2.2	2.8	0.6	
Улаан эсэргэнэ	тоо	366	480	421	-59	-12.3
	10 000 хүнд	2.3	2.89	2.51	-0.38	
Хоолны хордлого	тоо	346	606	256	-350	-57.8
	10 000 хүнд	2.1	3.65	1.53	-2.12	
Ёлом	тоо	209	145	105	- 40	-27.6
	10 000 хүнд	1.3	0.87	0.63	-0.24	
Бруцеллёз	тоо	4	4	5	1	25.0
	10 000 хүнд	0.02	0.02	0.03	0.01	
Гар, хөл, амны өвчин	тоо	1 362	871	5 555	4 684	6.4**
	10 000 хүнд	8.4	5.25	33.20	27.95	
Тэмбүү	тоо	2 549	2 051	1 861	- 190	-9.3
	10 000 хүнд	15.7	12.4	11.1	-1.3	
Гонококкт халдвар	тоо	1 117	1 209	1 002	- 207	-17.1
	10 000 хүнд	6.9	7.3	6.0	-1.3	
Трихомониаз	тоо	773	1 013	822	- 191	-18.9
	10 000 хүнд	4.8	6.1	4.9	-1.2	
Сүрьеэ	тоо	960	948	789	- 159	-16.8
	10 000 хүнд	5.9	5.7	4.7	-1.0	
ДОХ	тоо	18	25	23	-2	-8.0
	10 000 хүнд	0.11	0.15	0.14	-0.01	

**дахин их

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт:
Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):
Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):
Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):
Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох):
Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх:

Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

ГЭМТ ХЭРЭГ

Нийслэлд 28594 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1915 (7.2%) хэргээр өсжээ.

2026 оны эхний 9 сард 28594 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1915 (7.2%) хэргээр, гэмт хэргийн илрүүлэлт 43.6 хувьтай байгаа нь 6.7 нэгж хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 5538 хүн гэмтэж осолдон, 532 хүн нас барж, төр ард иргэдэд 660.9 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 185.0 тэрбум (28.0%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

ЗУРАГ 4. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 40.7 хувийг залилан, 16.5 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 17.8 хувийг хулгайн, 5.1 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 1.8 хувийг дээрмийн, 1.1 хувийг хүчин, 1.2 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 1.3 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 0.3 хувийг хүн амь, 14.2 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Төрөл	Гэмт хэргийн тоо			2026 I-IX / 2025 I-IX	
	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	Зөрүү	Хувь
НИЙТ	22 941	26 679	28 594	1 915	7.2
Хүний амь	78	76	90	14	18.4
Хүчин	275	316	375	59	18.7
Дээрэм	389	484	466	-18	-3.7
Хулгай	5 076	4 404	5 362	958	21.8
Залилан	8 369	11 008	11 199	191	1.7
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	4 088	4 313	4 712	399	9.3
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	896	1 374	1 434	60	4.4
Бусдыг амиа хорлоход хүргэх	297	327	399	72	22.0
Бусдын хөрөнгө ашиглах	448	376	378	2	0.5
Бусад гэмт хэрэг	3 025	4 001	4 032	178	4.4

2026 оны эхний 9 сард 9633 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2981 (44.8%) хүнээр өссөн байна.

ХҮСНЭГТ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			2026 I-IX / 2025 I-IX	
	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	Зөрүү	Хувь
НИЙТ	22 941	26 679	28 594	1 915	7.2
Багануур	226	281	300	19	1.1
Багахангай	14	25	22	-3	-12.0
Баянгол	3 640	4 273	5 344	1 071	25.1
Баянзүрх	6 692	6 890	6 740	-150	-2.2
Налайх	257	222	446	224	2.0**
Сонгинохайрхан	2 824	3 512	4 480	968	27.6
Сүхбаатар	3 389	3 846	4 163	317	8.2
Хан-Уул	3 521	4 492	4 155	-337	-7.5
Чингэлтэй	2 378	3 138	2 944	-194	-6.2

2026 оны эхний 9 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 25466 (89.0%) нь хөнгөн хэрэг, 3148 (11.0%) нь хүнд хэрэг байна.

ХҮСНЭГТ 7. ГЭМТ ХЭРЭГ БҮРТГЭГДЭХ ҮЕД СЭЖИГТНЭЭР ТООЦВОЛ ЗОХИХ ЭТГЭЭД НЬ ТОГТООГДООГҮЙ ХЭРГИЙН ТОО, 2026 оны эхний 9 сард

Дүүрэг	Хэрэг бүртгэлтийн хэргийн тоо	Үүнээс: Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
НИЙТ	27 405	11 955	43.6
Багануур	260	142	54.6
Багахангай	12	9	75.0
Баянгол	5 227	2 205	42.2
Баянзүрх	6 472	2 899	44.8
Налайх	420	170	40.5
Сонгинохайрхан	4 227	1 853	43.8
Сүхбаатар	4 013	1 737	43.3
Хан-Уул	3 963	1 710	43.1
Чингэлтэй	2 811	1 230	43.8

ЗУРАГ 5. ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТИЙН ХУВЬ, 2026 оны эхний 9 сард

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 2026 оны эхний 9 сард 14213 болж, өмнөх оны мөн үеэс 3601 (33.9%) хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 2220 (15.6%) нь согтуугаар, 1963 (13.8%) нь бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг байна. Сэжигтэн, яллагдагчийн 811 (5.7%) нь хүүхэд, 3331 (23.4%) нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр

Дүүрэг	Хулгайн гэмт хэргийн тоо, бүгд			Үүнээс: Хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо		
	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX
НИЙТ	5 076	4 404	5 362	3 579	3 118	4 163
Багануур	35	42	34	29	27	24
Багахангай	3	5	3	3	5	3
Баянгол	722	666	866	492	461	716
Баянзүрх	1 738	1 190	1 420	1 264	910	1 174
Налайх	29	25	71	26	24	52
Сонгинохайрхан	627	578	874	395	383	603
Сүхбаатар	699	624	776	463	410	559
Хан-Уул	779	867	789	617	645	646
Чингэлтэй	444	407	529	290	255	386

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг:
Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг:
Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч:
Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол:
Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч:
Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ

Нийслэлийн төсвийн нийт орлого 2940.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 684.5 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Нийслэлийн төсвийн нийт орлого 2026 оны эхний 9 сарын байдлаар 2940.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 684.5 (18.9%) тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Төсвийн нийт орлогын 2544.8 (86.5%) тэрбум төгрөгийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 395.7 (13.5%) тэрбум төгрөгийг татварын бус орлого тус тус эзэлж байна. 2026 оны эхний 8 сарын байдлаар татварын орлого 2544.8 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 492.8 (16.2%) тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 395.7 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 191.8 (32.6%) тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.

Орлогын албан татвар 469.4 (18.0%) тэрбум төгрөг, хөрөнгийн албан татвар 26.1 (11.4%) тэрбум төгрөгөөр тус тус дутуу, бусад татвар, төлбөр, хураамж 2.8 (1.4%) тэрбум төгрөгөөр илүү биелсэн байна.

ЗУРАГ 6. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА



ХҮСНЭГТ 9. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 оны эхний 9 сард, дүүргээр

Дүүрэг	Төсвийн орлого			Үүнээс					
				Татварын орлого			Татварын бус орлого		
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь
	сая төгрөг								
Нийслэлийн дүн	**3 625 091.2**	**2 940 548.1**	**- 18.9**	**3 037 623.9**	**2 544 840.1**	**- 16.2**	**587 467.3**	**395 708.0**	**- 32.6**
Баганууур	21 683.8	19 250.7	- 11.2	17 984.3	15 698.0	- 12.7	3 699.5	3 552.7	- 4.0
Багахангай	2 199.6	2 586.1	17.6	1 695.7	1 906.3	12.4	503.9	679.8	34.9
Баянгол	284 472.6	241 133.6	- 15.2	279 394.3	237 796.4	- 14.9	5 078.3	3 337.2	- 34.3
Баянзүрх	329 982.7	263 918.0	- 20.0	326 976.1	257 100.4	- 21.4	3 006.6	6 817.6	2.3**
Налайх	23 785.4	20 410.9	- 14.2	20 367.3	18 223.4	- 10.5	3 418.1	2 187.5	- 36.0
Сонгинохайрхан	161 718.2	126 325.2	- 21.9	159 065.5	122 245.6	- 23.1	2 652.7	4 079.6	53.8
Сүхбаатар	618 401.3	474 259.2	- 23.3	614 966.2	461 275.0	- 25.0	3 435.1	12 984.2	3.8**
Хан-Уул	508 685.5	431 761.6	- 15.1	503 516.0	424 882.4	- 15.6	5 169.5	6 879.2	33.1
Чингэлтэй	258 658.9	228 162.4	- 11.8	253 930.3	221 669.4	- 12.7	4 728.6	6 493.0	37.3
Хотын шууд	1 415 503.2	1 132 740.4	- 20.0	859 728.2	784 043.2	- 8.8	555 775.0	348 697.2	- 37.3

ХҮСНЭГТ 10. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 оны эхний 9 сард

Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Өөрчлөлт	
	сая төгрөг		Дүн	Хувь
Нийт орлого	**3 625 091.2**	**2 940 548.2**	**-684 543.0**	**- 18.9**
Татварын орлого	**3 037 623.9**	**2 544 840.1**	**-492 783.8**	**- 16.2**
Орлогын албан татвар	2 608 864.4	2 139 415.4	-469 449.0	- 18.0
Хувь хүний орлогын албан татвар	1 906 252.5	1 544 962.9	-361 289.6	- 19.0
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын	1 483 335.7	1 073 653.8	-409 681.9	- 27.6
Үйл ажиллагааны орлогын	51 693.6	47 762.8	-3 930.8	- 7.6
Хөрөнгийн орлого	137 864.9	145 894.4	8 029.5	5.8
Хөрөнгө борлуулсны орлогын	87 091.6	98 002.9	10 911.3	12.5
Шууд бус орлого	146 266.7	179 649.0	33 382.3	22.8
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-57 500.0	-57 188.7	311.3	- 0.5
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	760 11 1.9	651 641.2	-108 470.7	- 14.3
Хөрөнгийн албан татвар	230 131.2	204 004.0	-26 127.2	- 11.4
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	115 085.9	86 887.1	-28 198.8	- 24.5
Бууны албан татвар	349.8	318.0	- 31.8	- 9.1
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	114 543.3	116 643.9	2 100.6	1.8
Малд ногдуулах албан татвар	152.2	155.0	2.8	1.8
Бусад татвар, төлбөр, хураамж	198 628.3	201 420.7	2 792.4	1.4
Бусад нийтлэг төлбөр, хураамж	84 204.0	69 174.4	-15 029.6	- 17.8
Газрын төлбөр	82 659.3	100 089.7	17 430.4	21.1
Байгалийн нөөц ашигласны төлбөр	3 461.3	3 305.3	- 156.0	- 4.5
Бусад татвар	28 303.7	28 851.3	547.6	1.9
Татварын бус орлого	**587 467.3**	**395 708.1**	**-191 759.2**	**- 32.6**
Нийтлэг татварын бус орлого	554 467.3	395 708.1	-158 759.2	- 28.6
Хувьцааны ногдол ашиг	1 400.0	643.8	- 756.2	- 54.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	37 221.4	47 563.4	10 342.0	27.8
Торгуулийн орлого	165 761.3	156 541.9	-9 219.4	- 5.6
Түрээсийн орлого	1 667.9	1 360.7	- 307.2	- 18.4
Хүүгийн орлого	86 642.6	77 291.6	-9 351.0	- 10.8
Бусад орлого	261 774.1	112 306.7	-149 467.4	- 57.1
Өмч хувьчлал	33 000.0	0.0	-33 000.0	I

ЗУРАГ 7. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО



ХҮСНЭГТ 11. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2026 оны эхний 9 сард

Үзүүлэлт	Зарлага		Өөрчлөлт	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	сая төгрөг			
Нийслэлийн дүн	**3 822 737.2**	**3 281 423.3**	**- 541 313.9**	**-14.2**
Багануур	28 101.6	26 420.3	-1 681.3	- 6.0
Багахангай	13 885.3	11 186.5	-2 698.8	- 19.4
Баянгол	91 868.8	79 479.8	-12 389.0	- 13.5
Баянзүрх	159 068.6	123 716.5	-35 352.1	- 22.2
Налайх	30 248.1	26 315.4	-3 932.7	- 13.0
Сонгинохайрхан	145 455.8	119 023.6	-26 432.2	- 18.2
Сүхбаатар	162 854.6	129 079.3	-33 775.3	- 20.7
Хан-Уул	149 502.7	107 614.4	-41 888.3	- 28.0
Чингэлтэй	116 184.2	89 424.6	-26 759.6	- 23.0
Хотын шууд	2 925 567.5	2 569 162.9	-356 404.6	- 12.2

2026 оны эхний 9 сарын байдлаар нийслэлийн төсвөөс нийслэл, дүүргийн байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 3281.4 (85.8%) тэрбум төгрөгийг санхүүжүүлжээ.

Өөрөөр хэлбэл нийслэл, дүүргийн байгууллагууд батлагдсан төсвийнхөө 541.3 (14.2%) тэрбум төгрөгийг зарцуулаагүй байна.

ЗУРАГ 8. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА



Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого:
Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого:
Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого:
Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар өслөө.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2026 оны 9 дүгээр сард нийслэлийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар, өмнөх сараас 0.4 хувиар өссөн байна.

ЗУРАГ 9. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний үнийн индекс 2026 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 19.8 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис бүлгийн үнэ 15.5 хувь, хувцас бөс бараа гутал бүлгийн үнэ 5.8 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 7.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 7.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний үнэ 7.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 18.7 хувь, даатал санхүүгийн үйлчилгээний үнэ 23.8 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 9.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 12. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа үйлчилгээний бүлгийн нэр	2025-IX / 2024-IX	2026-IX / 2025-IX	2026-IX / 2025-XII	2026-IX / 2026-VIII
	Хувь			
Ерөнхий индекс	9.9	11.9	10.4	0.4
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	11.2	19.8	16.7	-1.4
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	7.4	15.5	11.4	1.9
Хувцас, бөс бараа, гутал	8.1	5.8	2.8	0.3
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	23.4	6.4	5.9	0.2
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	7.9	7.5	6.5	0.2
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	7.6	7.2	5.9	0.3
Тээвэр	4.8	8.6	9.2	3.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	2.4	1.4	1.3	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	5.4	7.6	5.0	0.0
Боловсролын үйлчилгээ	13.6	18.6	18.6	0.4
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	9.6	18.7	18.0	2.5
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	6.1	23.8	23.8	0.0
Бусад бараа, үйлчилгээ	7.7	9.6	4.4	1.2

2026 оны 9 дүгээр сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 418 төрлийн бараа, үйлчилгээний үнийг өмнөх сартай харьцуулахад 113 (27.0%) бараа үйлчилгээний үнэ өсөж, 23 (5.5%) бараа үйлчилгээний үнэ буурч, 282 (67.5%) бараа үйлчилгээний үнэ тогтвортой байв.

ЗУРАГ 10. НЭГ ШИРХЭГ ТАЛХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 дүгээр сард



ЗУРАГ 11. НЭГ КИЛОГРАММ САВЛАСАН ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 дүгээр сард



ЗУРАГ 12. НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 дүгээр сард

ЗУРАГ 13. **НЭГ ЛИТР ТАРАГ, СҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 дүгээр сард**



ХҮСНЭГТ 13. **НЭГ КИЛОГРАММ МАХНЫ ЖИЖИГЛЭН ХУДАЛДАХ ДОЛОО ХОНОГИЙН ДУНДАЖ ҮНЭ, сараар**

Үхрийн ястай мах												
Он	I	II	III	IV	V	VI	VII	VII	IX	X	XI	XII
төгрөг												
2021	11 614	12 606	12 666	13 853	13 956	14 768	14 793	13 700	13 420	13 277	13 342	13 493
2022	14 059	13 999	14 255	14 532	15 144	15 387	15 119	14 236	13 730	13 562	13 226	13 395
2023	13 610	14 416	15 072	16 747	18 476	20 100	19 040	16 436	16 277	15 688	15 542	15 842
2024	16 436	17 149	17 624	18 126	19 531	18 895	18 533	17 735	18 137	17 864	17 783	18 261
2025	19 073	19 637	19 932	20 064	20 280	21 285	21 524	20 793	20 755	20 810	20 689	21 343
2026	23 570	24 581	26 178	28 911	31 278	33 922	33 304	31 843	31 210			
Хонины ястай мах												
Он	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
төгрөг												
2021	9 034	10 459	10 692	12 318	12 389	12 696	12 440	11 380	10 974	11 006	10 773	10 846
2022	11 530	11 939	12 585	12 620	12 705	12 803	12 358	11 526	11 022	10 238	9 806	9 918
2023	10 545	11 721	12 820	14 062	15 369	16 597	15 288	13 237	12 702	12 006	11 834	12 078
2024	12 923	13 776	13 917	14 628	16 054	16 355	15 294	14 745	14 510	14 245	14 088	14 697
2025	15 560	16 495	17 177	17 458	17 270	17 088	17 005	16 830	16 696	16 675	16 553	16 909
2026	18 179	19 181	21 214	24 968	26 558	27 679	27 627	26 467	26 132			

2026 оны 9 дүгээр сард хүнсний зах, супермаркет, бөөний төвүүдэд жижиглэн худалдаалагдаж буй үхрийн ястай махны үнэ өмнөх сартай харьцуулахад 2.0 хувиар, хонины ястай махны үнэ 1.3 хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 14. **НЭГ КГ ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, 9 дүгээр сард**



ЗУРАГ 15. НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, өөрчлөлт орсон өдрөөр



ХҮСНЭГТ 14. ТҮЛШНИЙ ҮНЭ, байршлаар

Байршил	2024.IX.30			2025.IX.29			2026.IX.28			
	Түлшний мод шуудай (6-7 кг)		Сайж-руулсан түлш 25 кг	Түлшний мод шуудай (6-7 кг)		Сайж-руулсан түлш 25 кг	Түлшний мод шуудай (6-7 кг)		Хагас коксон шахмал түлш 25 кг	Сайж-руулсан түлш 25 кг
	Хар мод	Нарс мод		Хар мод	Нарс мод		Хар мод	Нарс мод		
	төгрөг									
Хүчит шонхор зах	7 500	7 000	3 750	7 500	7 000	3 750	8 500	8 500	5 000	3 750
Сүхбаатар	7 500	7 000	3 750	7 500	7 000	3 750	9 000	9 000	5 000	3 750
Цайз зах	8 500	7 500	3 750	8 000	8 000	3 750	8 000	8 000	5 000	3 750
Хангай зах	7 000	7 000	3 750	7 000	7 000	3 750	8 000	8 000	5 000	3 750
Дундаж үнэ	**7 625**	**7 125**	**3 750**	**7 500**	**7 250**	**3 750**	**8 365**	**8 365**	**5 000**	**3 750**

ХҮСНЭГТ 15. ШАТАХУУНЫ ҮНЭ, төрлөөр

ШТС	2025.IX.29					2026.IX.28				
	Аи 95	Аи 92 евро	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 92 евро	Аи 92	Дизель түлш	Газ
	Төгрөг									
Тэс	-	-			-	-	4 950	3 040	4 790	-
Петровис	3 610	-	2 590	2 940	-	4 990	4 960	3 040	4 780	-
Сод монгол	3 610	-	2 590	2 940	-	4 110	3 290	3 040	4 770	-
Шунхлай	3 610	-	2 590	2 940	-	5 180	4 970	3 040	4 760	-
Юнигаз	-	-	-	-	1 950	-	-	-	-	2 450
Дундаж үнэ	**3 610**	**-**	**2 590**	**2 940**	**1 950**	**4 674**	**4 476**	**3 040**	**4 775**	**2 450**

ЗУРАГ 16. АМ.ДОЛЛАРЫН ХАНШИЙН САРЫН ДУНДАЖ ХӨДӨЛГӨӨН[1]



[1] Эх үүсвэр: Монголбанкны статистикийн мэдээлэл

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс:
Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин:
Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ):
Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:
ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томьёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^{L} = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}}\right)\left(\frac{P_{it-1}}{P_{it-2}}\right)\cdots\left(\frac{P_{i2}}{P_{i1}}\right)\left(\frac{P_{i1}}{P_{i0}}\right)\frac{P_{i0}Q_{i0}}{\sum P_{i0}Q_{i0}}$$

I_{ct}^{L} – t тайлант үеийн Ласдейресийн үнийн индекс
t – Тайлант үе
0 – суурь үе
p_t^i – i барааны тайлант үеийн үнэ
p_0^i – i барааны тайлант үеийн үнэ
q_0^i – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 3 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 418 бараа, үйлчилгээ (аймагт 333 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2023 оны үр дүнгээр жинг тооцон, 2023 оны дундаж үнийн суурьтайгаар 2025 оны 2 дугаар сараас эхлэн тархааж байна.

ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.

МАЛ АЖ АХУЙ

Нийслэлийн хэмжээнд 2026 оны эхний 9 сарын байдлаар 4361 толгой том мал хорогджээ.

2026 оны эхний 9 сарын байдлаар 4361 толгой том мал зүй бусаар хорогдож, том малын зүй бус хорогдлын 1619 (37.1%) нь хээлтэгч мал байна. Хорогдсон нийт малын 21.9 хувийг адуу, 35.5 хувийг үхэр, 18.2 хувийг хонь, 24.4 хувийг ямаа эзэлжээ.

ХҮСНЭГТ 16. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, дүүргээр

Дүүрэг	2025 I-IX		2026 I-IX		Өөрчлөлт	
	Хорогдсон мал	Хээлтэгч	Хорогдсон мал	Хээлтэгч	Дүн	хувь
	толгой					
Бүгд	1 259	498	4 361	1 619	3 102	3.4**
Багануур	270	79	563	186	293	2.1**
Багахангай	134	11	816	90	682	6.1**
Баянзүрх	243	90	871	408	628	3.6**
Налайх	121	49	1 068	447	947	8.8**
Сонгинохайрхан	283	196	497	358	214	75.6
Хан-Уул	208	73	546	130	338	2.6**

ЗУРАГ 17. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДЛЫН МЭДЭЭ, сараар



<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

<u>Том малын зүй бус хорогдол:</u>
Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй) зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

<u>Бэлэн хээлтэгч:</u>
Малын төрөл бүр дэх нас гүйцсэн эм малыг хамруулна.

<u>Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь:</u>
Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

МАЛ ТӨЛЛӨЛТ, БОЙЖИЛТ:

Нийслэлийн хэмжээнд төл бойжилт 98.8 хувьтай байна.

Нийслэлийн хэмжээнд 2025 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 200719 толгой хээлтэгч малын 120537 (60.1%) нь 2026 оны эхний 9 сарын байдлаар төллөсөн байна. Нийт 120537 төл гарсны 1877 төл мал хорогдож, 118660 төл бойжиж, төл бойжилт 98.4 хувьтай байна.

ЗУРАГ 18. **БОЙЖУУЛСАН ТӨЛИЙН ТОО, жил бүрийн эхний 9 сарын байдлаар**



Мал төллөлтийн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад төллөсөн хээлтэгч 8552 (6.6%) толгойгоор, бойжсон төл 8847 (6.9%) толгойгоор тус тус буурсан байна. Бойжуулсан нийт төлийн 14.5 хувийг унага, 23.7 хувийг тугал, 35.9 хувийг хурга, 25.9 хувийг ишиг эзэлжээ.

ХҮСНЭГТ 17. **МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жилийн бүрийн эхний 9 сарын байдлаар**

Эх малын төрөл	Оны эхний хээлтэгч		Хорогдсон хээлтэгч		Төллөсөн хээлтэгч	
	2025	2026	2025 I-IX	2026 I-IX	2025 I-IX	2026 I-IX
	толгой					
Бүгд	**206 465**	**200 719**	**498**	**1 619**	**129 089**	**120 537**
Гүү	35 901	39 358	101	342	15 033	17 387
Үнээ	46 801	49 231	120	726	26 855	28 721
Ингэ	32	27	-	-	13	1
Эм хонь	71 300	64 836	127	266	50 321	43 131
Эм ямаа	52 431	47 267	150	285	36 867	31 297

Эм хонины 43131 толгой буюу 66.5 хувь, эм ямааны 31297 толгой буюу 66.2 хувь, үнээний 28721 толгой буюу 58.3 хувь, гүүний 17387 толгой буюу 44.2 хувь, ингэний 1 толгой буюу 3.7 хувь нь тус тус төллөсөн байна.

ХҮСНЭГТ 18. **ТӨЛ БОЙЖИЛТ, дүүргээр, эхний 9 сарын байдлаар**

Дүүрэг	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Төл Бойжилт
	толгой				
Дүн	**120 537**	**120 537**	**1 877**	**118 660**	**98.4**
Багануур	55 685	55 685	530	55 155	99.0
Багахангай	10 736	10 736	426	10 310	96.0
Баянзүрх	10 338	10 338	288	10 050	97.2
Налайх	6 959	6 959	103	6 856	98.5
Сонгинохайрхан	16 376	16 376	300	16 076	98.2
Хан-Уул	20 443	20 443	230	20 213	98.9

ХҮСНЭГТ 19. ТӨЛ БОЙЖИЛТ, малын төрлөөр, эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	2024	2025	2026					
				Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
	толгой							
Гарсан төл	94 235	129 089	120 537	1	17 387	28 721	43 131	31 297
Бойжсон төл	89 999	127 507	118 660	1	17 224	28 147	42 540	30 748
Хорогдсон төл	4 236	1 582	1 877	-	163	574	591	549
Бойжилтын хувь	**95.5**	**98.8**	**98.4**	**100.0**	**99.1**	**98.0**	**98.6**	**98.2**

Ойлголт, тодорхойлолт:

Төллөлтийн хувь:
Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулж тооцно.

Төл бойжилтын хувь:
Бойжуулсан төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж тооцно.

АЖ ҮЙЛДВЭР

Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 60.8 хувиар өслөө.

